



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 2,354,643,458.20 (Хоёр тэрбум гурван зуун тавин дөрвөн сая зургаан зуун дөчин гурван мянга дөрвөн зуун тавин найман төгрөг хорин мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг болох техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг заалт бүрээр ханган ажиллах, төлөвлөлтийг сайжруулах;

2.2.Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

2.3.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3.“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д Төрийн өмчийг эзэмшиүүлэх гэрээний 4.2. дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаж, санхүүгийн сахилга батыг хэвшиүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай;

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;  
Эд хөрөнгийн харилцааны зохицуулалт болон үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх журам, жишиг үнийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулан мөрдөж ажиллах;


3.2.Компанийн нэр дээр бүртгэлтэй эзэмшил тодорхойгүй болон баталгаажилт хийгдээгүй 4 нэгж талбарын 1,923.0 м<sup>2</sup> газрыг баталгаажуулах, төрийн мэдээллийн “Хур” системд залруулга хийлгэх, эзэмших, ашиглах эрхийг үнэлж эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авч бүртгэлд тусгах;

3.3.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахыг таслан зогсоох;

3.4.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллах;

3.5.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 3 дугаар сарын 06..-ны өдрийн 107.. дугаар тогтоолын хавсралт

**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИД ХИЙСЭН  
БАРИМТЫН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ,  
ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

№	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал	
1	Худалдан авах ажиллагаатай холбоотой	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээ	259,906,358.2	Төсвийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”, ТУЗ болон гүйцэтгэх захирлын хооронд байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г мөрдөж ажиллах;
		Батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлсэн	79,560,200.0	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг мөрдөж ажиллах;
		Тендер шалгаруулалтын аргыг буруу хэрэглэсэн	515,176,900.0	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг мөрдөж ажиллах;
2	Монгол банкнаас тогтоосон зохицой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг тооцоогүй болон сонгон шалгаруулалтгүй байршуулсан хадгаламж	1,500,000,000.0	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А-1/459 дүгээр албан бичгээр өгсөн чиглэлийг мөрдөж ажиллах.	
<b>ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН:</b>		<b>2,354,643,458.20 (хоёр тэрбум гурван зуун тавин дөрвөн сая зургаан зуун дөчин гурван мянга дөрвөн зуун тавин найман төгрөг хорин мөнгө)</b>		